



## ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/02

Улаанбаатар хот

### Хоол, унааны нэмэгдлийг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Газрын дүрмийн 7.1.1, Хөдөлмөрийн дотоод журмын 6.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Албан хаагчдын нэг өдрийн хоолны хөнгөлөлтийг 9000 (есөн мянга), нийтийн тээврийн унааны хөнгөлөлтийг 1000 (нэг мянга) төгрөгөөр байхаар тус тус шинэчлэн тогтоож баталсугай.

2. Батлагдсан хоол, унааны нэмэгдлийг Төрийн албаны зөвлөлийн "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" нэгдсэн системд шинэчлэн оруулж 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс тус тус тооцож сар бүр олгож ажиллахыг Ахлах нягтлан бодогч (Б.Түмэнжин)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-д даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/05 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

С.ТӨМӨРДУЛАМ